



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/01/-НА-СТА-ААТҮГ

---

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: <a href="mailto:gerleen1111@gmail.com">gerleen1111@gmail.com</a></p>
---	---

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	
3.8 Аудитын гол асуудал .....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 170

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Тайлант онд и баримтгүй хийсэн, татварын тодорхойлолтоор зөрүүтэй тайлагнасан, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүй, өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан зэрэг нийт 81.9 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,510,346.93</b>	<b>47,581,391.24</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>276,379.03</b>	<b>1,923,656.34</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>276,379.03</b>	<b>1,923,656.34</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>276,379.03</b>	<b>1,923,656.34</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	276,379.03	1,923,656.34
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>31,179,347.90</b>	<b>28,908,624.90</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>31,179,347.90</b>	<b>28,908,624.90</b>
33510	Байгууллагаас авах авлага	31,179,347.90	28,908,624.90
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>12,054,620.00</b>	<b>16,749,110.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,054,620.00</b>	<b>16,749,110.00</b>
35420	Аж ахуйн материал	10,913,020.00	15,733,860.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,141,600.00	1,015,250.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>432,589,866.65</b>	<b>242,484,941.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>432,589,866.65</b>	<b>242,484,941.12</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>268,735,866.65</b>	<b>78,630,941.12</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	273,869,251.89	273,504,451.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,342,116.15	-197,075,635.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,550,000.00	450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,450,000.00	-450,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	56,640,763.00	57,705,763.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,757,032.09	-55,578,638.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,748,777.00	19,762,876.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,523,777.00	-19,687,876.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>163,854,000.00</b>	<b>163,854,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	163,854,000.00	163,854,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>476,100,213.58</b>	<b>290,066,332.36</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>38,437,420.20</b>	<b>41,787,940.82</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>38,437,420.20</b>	<b>41,787,940.82</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>38,437,420.20</b>	<b>41,787,940.82</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>38,437,420.20</b>	<b>41,787,940.82</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	10,847,200.00	17,647,200.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	27,590,220.20	24,140,740.82
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>437,662,793.38</b>	<b>248,278,391.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>437,662,793.38</b>	<b>248,278,391.54</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,575,633.26	249,575,633.26
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-207,098,216.93</b>	<b>-396,482,618.77</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-119,141,451.13	-207,098,216.93
51220	Тайлант үеийн үр дүн	-87,956,765.80	-189,384,401.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	395,185,377.05	395,185,377.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>476,100,213.58</b>	<b>290,066,332.36</b>


### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>429,130,071.00</b>	<b>413,423,183.08</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>26,391,803.08</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>0.00</b>	<b>26,391,803.08</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>0.00</b>	<b>26,391,803.08</b>
110003	Хөрөнгийн орлого	0.00	26,391,803.08
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>429,130,071.00</b>	<b>387,031,380.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>429,130,071.00</b>	<b>387,031,380.00</b>
120009	Бусад орлого	408,266,096.00	352,224,400.00

120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	20,863,975.00	34,842,980.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	0.00	36,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>517,086,836.80</b>	<b>602,807,584.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>517,086,836.80</b>	<b>602,807,584.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>517,086,836.80</b>	<b>602,807,584.92</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>459,077,647.05</b>	<b>401,344,262.06</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	459,077,647.05	401,344,262.06
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,009,189.75</b>	<b>201,463,322.86</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,009,189.75	201,463,322.86
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-87,956,765.80</b>	<b>189,384,401.84</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-87,956,765.80</b>	<b>189,384,401.84</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,475,633.26	331,949,542.43	-119,141,451.13	458,283,724.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,475,633.26	331,949,542.43	-119,141,451.13	458,283,724.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	63,235,834.61	0.00	63,235,834.61
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,100,000.00	0.00	0.00	4,100,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-87,956,765.80	-87,956,765.80
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	-207,098,216.93	437,662,793.38
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	-207,098,216.93	437,662,793.38
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.04	-207,098,216.93	437,662,793.37
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-189,384,401.84	-189,384,401.84
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	-396,482,618.77	248,278,391.54



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>429,015,071.00</b>	<b>393,458,216.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,548,975.00</b>	<b>41,233,816.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>24,548,975.00</b>	<b>41,233,816.00</b>
120009	Бусад орлого	5,485,000.00	5,366,400.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	19,063,975.00	34,342,580.00
120015	Даатгалын нөхвөрөөс хилээн авсан мөнгө /ТӨҮГ/	0.00	1,524,836.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>404,466,096.00</b>	<b>352,224,400.00</b>
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>404,466,096.00</b>	<b>352,224,400.00</b>
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	404,466,096.00	352,224,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>424,052,066.71</b>	<b>390,380,938.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>424,052,066.71</b>	<b>390,380,938.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>424,052,066.71</b>	<b>390,380,938.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>288,480,990.00</b>	<b>274,286,436.30</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	288,480,990.00	274,286,436.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80,843,748.27</b>	<b>65,619,757.39</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	80,843,748.27	65,619,757.39
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,459,500.00</b>	<b>40,635,310.00</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	5,583,250.00	8,095,240.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	35,876,250.00	32,540,070.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,267,828.44</b>	<b>9,839,435.00</b>
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	13,267,828.44	9,839,435.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,963,004.29</b>	<b>3,077,277.31</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,173,700.00</b>	<b>1,430,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,173,700.00</b>	<b>1,430,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,173,700.00</b>	<b>1,430,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,173,700.00	1,430,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-6,173,700.00</b>	<b>-1,430,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-1,210,695.71</b>	<b>1,647,277.31</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,487,074.74	276,379.03
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	276,379.03	1,923,656.34

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажиллагааны орлого	40,200,000.0	34,770,980.00	5,429,020.0	86%
Бусад орлого		26,427,803.08	(26,427,803.1)	
Санхүүжилт	331,350,000.0	352,224,400.00	(20,874,400.0)	106%
<b>ОРЛОГО</b>	<b>371,550,000.0</b>	<b>413,423,183.1</b>	<b>(41,873,183.1)</b>	
<b>1.3 Нийт ашиг</b>	<b>371,550,000.00</b>	<b>413,423,183.08</b>	<b>- 41,873,183.08</b>	<b>111%</b>
Цалин	331,350,000.0	350,503,596.39	(19,153,596.4)	106%
Томилолт		36,000.00	(36,000.0)	
Хангамжийн материал		29,356,034.00	(29,356,034.0)	

Бусад	32,200,000.0	222,911,954.53	(190,711,954.5)	692%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	363,550,000.00	602,807,584.92	-239,257,584.92	166%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	8,000,000.00	- 189,384,401.84	197,384,401.84	-2367%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	8,000,000.00	- 189,384,401.84	197,384,401.84	-2367%
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	8,000,000.00	- 189,384,401.84	197,384,401.84	- 23.67
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	8,000,000.00	- 189,384,401.84	197,384,401.84	- 23.67

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.


#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл нь зочид буудал, амралтын газар, түр хоноглох байрны үйлчилгээ, төрийн байгууллагын туслах үйл ажиллагаа, зоогийн газар, гуанз цайны газрын үйлчилгээ эрхлэнэ.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 430.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 602.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 9.3 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга


#### Байгууллагын үйл ажиллагаа

Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын зорилго нь аймгийн Засаг дарга түүний Тамгын газар, төр захиргааны байгууллага, агентлагуудын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд үйлчлэх үүрэг бүхий үйл ажиллагааг эрхлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг зочид буудал, амралтын газар, түр хоноглох байрны үйлчилгээ, төрийн байгууллагын туслах үйл ажиллагаа, зоогийн газар, гуанз цайны газрын үйлчилгээг эрхлэн явуулна гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд улсын төсөвт үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна. Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газар нь аймгийн Засаг даргын 2001 оны 175 дугаар захирамжийг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай 35 дугаар зүйлд "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх: ... 35.1.12.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн эрхийг орон нутагт тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлэхээр заасан.



Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тодорхой ажил хийхээр тусгагдаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцэд 1 ажилтан өндөр насны тэтгэвэртээ гарч түүний ажлын байранд 1 ажилтан авч ажиллуулсан байна, чиг үүргийн хувьд орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг тогтмол олгосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар тусгасан.

### 3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	276.4	1,923.7	1,647.3
БХХО			
Авлага	31,179.3	28,908.6	-2,270.7
Урьдчилгаа			
Бараа материал	12,054.6	16,749.1	4,694.5
Үндсэн хөрөнгө	432,589.9	242,484.9	-190,105.0
Биет бус хөрөнгө			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>476,100.2</b>	<b>290,066.3</b>	<b>-186,033.9</b>
Өр төлбөрийн дүн	38,437.4	41,787.9	3,350.5
Богино хугацаат өглөг	38,437.4	41,787.9	3,350.5
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	437,662.8	248,278.4	-189,384.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>476,100.2</b>	<b>290,066.3</b>	<b>-186,033.9</b>

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 0.20 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн түрээсийн үлдэгдэл 0.88 сая төгрөг, Шүүхийн шийдвэрийн авлага 12.3 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 15.8 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд үйл ажиллагааны хүрээнд үүссэн авлагыг барагдуулж ажилласан мөн өмнөх онуудад үүссэн авлагыг 2.3 сая төгрөгөөр бууруулсан нь авлагын бууралтад нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 27.8 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 0.95 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16.7 сая төгрөг болж 4.7 сая төгрөгөөр өссөн нь бараа материал худалдан авсан, бараа материал шилжүүлэн авсан нь тус тус шалтгаалжээ.

Тайлант онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5.2 сая төгрөгийн аж ахуйн материал, хандиваар 2.3 сая төгрөгийн бараа материал, худалдан авалтаар 40.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч 43.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 1.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор үнэ төлбөргүй 10.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авснаар тус тус нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгөөс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор нийт 7,0 сая төгрөгийн өртөгтэй, 7.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 23 ширхэг хөрөнгийг акталсан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 34 дүгээр тогтоолоор 4.1 сая төгрөгийн төгрөгийн өртөгтэй, 4.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 3 ширхэг авто тээврийн хэрэгслийг тус тус акталсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 41.8 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өртөг зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг өртгөөр зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, цалингийн зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад нийт зардал 143.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэн нь шалтгаалжээ.

### **3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Нийтлэг-Үйлчилгээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 69 дүгээр тушаалаар “Нийтлэг-Үйлчилгээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 352.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 344.1 сая төгрөгөөр, 8.0 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Тодотголоор 19.5 сая төгрөгийг нэмж тодотгон нийт орлого 371.6 сая төгрөг, нийт зарлага 363.6 сая төгрөг болсон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төлөвлөөгүй.

Гүйцэтгэлээр 413.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 602.8 сая төгрөгийн зардал гарган, 189.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 371.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 413.4 сая төгрөг буюу 11.2 хувиар давсан нь тайлант онд үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан, НӨАТ-ын өглөг татварын хяналтаар буурч орлогод бүртгэгдсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 363.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 602.8 сая төгрөг буюу 65.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь элэгдлийн зардал нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 189.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 181.4 сая төгрөгөөр илүү байгаа нь зардал өссөн, элэгдлийн зардал зэрэг нөлөөлж байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийтлэг үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 417,471.6 мянган төгрөгийн 35 мэдээллээс аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл, авлага үүсгэсэн 18 шийдвэрийн талаарх 28,908.6 мянган төгрөгийн мэдээлэл, өглөг үүссэн 4 шийдвэрийн 41,787.9 мянган төгрөгийн нийт 70,696.3 мянган төгрөгийн мэдээллүүдийг тус тус байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 1.1 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж,

бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 0.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 66.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснээс 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 0,7 сая төгрөгийн албан шаардлага 20.3 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 0.7 сая төгрөгийн албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 4.5 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Мөн өмнөх онуудын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын 9.5 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй бөгөөд тус актыг дахин давтан тооцоолох, 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор төлж барагдуулахаар шийдвэрлэсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэсэн эсэх, и баримтгүй гүйлгээ хийсэн эсэх, өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажилласан эсэх, зардлын төлөвлөгөөг хэтрүүлэн зарцуулсан, төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажилласан, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг тус тус шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27.0 сая төгрөгийн алдааг залруулж, 48.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.2.1 Залруулсан алдаа

Тайлант онд 1.1 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн. Татварын тодорхойлолтын 25.9 сая төгрөгийн зөрүүг арилгаж аудитын явцад залруулсан.

### 4.2.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.2.3 Албан шаардлага

Тайлант онд 0.24 сая төгрөгийн гүйлгээг и баримтгүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Орлогын дүн нь НӨАТ-ын тайлангаас 0.0002 сая төгрөгөөр дутуу, үр дүнгийн тайлангаас 0.07 сая төгрөгөөр илүү байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн

16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 2.3 сая төгрөгөөр дутуу, 0.16 сая төгрөгөөр илүү тайлагнасан зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр өндөр насны тэтгэвэрт гарсан албан тушаалтны оронд шинээр ажилтан авч ажиллуулан 2.1 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2.-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй байгаа 1.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын төлөвлөгөөг 41.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж алдагдалтай ажилласан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 417.5 сая төгрөгийн 35 мэдээллээс аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл, авлага үүсгэсэн 18 шийдвэрийн талаарх 28.9 сая төгрөгийн мэдээлэл, өглөг үүссэн 4 шийдвэрийн 41.8 сая төгрөгийн нийт 70.6 сая төгрөгийн мэдээллүүдийг тус тус байршуулаагүй байна. заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнгээс 179.7 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.2. "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.2.4 Зөвлөмж

Аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Аймгийн засаг даргад

**1.1 Илрүүлэлт:** Эрдэнэ Эрчим хүч аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

**1.1 Өгсөн зөвлөмж:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.1-т "Аймгийн Засаг Дарга нь Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТБОНӨХЭ	9	73.7	1	25.9	-	-	7	47.8	1	
Дүн		<b>9</b>	<b>73.7</b>	<b>1</b>	<b>25.9</b>	-	-	<b>7</b>	<b>47.8</b>	<b>1</b>	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТБОНӨХЭ	2	1.3	1	1.1	-	-	1	0.2	-	-
Дүн		2	1.3	1	1.1	-	-	1	0.2	-	-
Нийт дүн		<b>11</b>	<b>75.0</b>	<b>2</b>	<b>27.0</b>	-	-	<b>8</b>	<b>48.0</b>	<b>1</b>	